



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дугаар захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалт, 4 дүгээр хэсгийн 4.5.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Түргэн үйлчилгээний цэг байгууламжид Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг шалгах, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, зөвшөөрөлгүй Түргэн үйлчилгээний цэгүүдийн судалгаа гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байршиж буй түргэн үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийх удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалтыг удирдамжид заасны дагуу зохион байгуулж дүгнэлтийг 2016 оны 09 дүгээр сарын 05-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг /О.Нарантуяа/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

УХА0551 9077367



Ажлын хэсгийн дарга	О.Нарантуяа	Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга
	Э.Анар	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга
	Л.Эрдэнэчулуун	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга
	Ч.Болдбаатар	Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга
	Ш.Төмөрбаатар	Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга
	Ж.Ганхуяг	Хан Уул дүүргийн Засаг дарга
	Ж.Сандагсүрэн	Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга
	Д.Оросоо	Баянгол дүүргийн Засаг дарга
	Ж.Эрдэнэбат	Чингэлтэй дүүргийн Засаг дарга
	Д.Бадарсан	Сүхбаатар дүүргийн Засаг дарга
	Д.Пүрэвдаваа	Баянзүрх дүүргийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Т.Сэргэлэн	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс худалдаа, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн
А/1103-р дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УХА0501 9077367

НИЙСЛЭЛИЙН ТӨВИЙН 6 ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРШИЖ БУЙ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГҮҮДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг шалгах, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, зөвшөөрөлгүй Түргэн үйлчилгээний цэгүүдийн судалгааг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

Шалгалтыг Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байршиж буй түргэн үйлчилгээний цэгүүдийг хамруулан 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулна.

Гурав. Шалгалтын бүрэлдэхүүн

Шалгалтыг Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Эрдэнэцэцэг, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Т.Сэргэлэн, Баянзүрх, Хан Уул дүүрэгт Үйл ажиллагаа мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Б.Туул нарын ахалсан ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулж явуулна. Үүнд:

№	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Шалгах дүүрэг
1	Ц.Цэрэнпунцаг -99000969 /Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн дарга/ Д.Энхбат -99084353 /Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга/ Н.Баяр -99119218 /Нийслэлийн өмчийн харилцааны газрын Газар чөлөөлөх хэлтсийн дарга/ /Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын хариуцсан хэлтэс/	Сүхбаатар Чингэлтэй

	<p>Н.Цогзолмаа -99114853 /Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга/ Д.Булган -99115677 /Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга/</p>	
2	<p>Ц.Цэрэнпунцаг -99000969 /Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн дарга/ Д.Энхбат -99084353 /Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга/ Н.Баяр -99119218 /Нийслэлийн өмчийн харилцааны газрын Газар чөлөөлөх хэлтсийн дарга/ /Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын хариуцсан хэлтэс/ Б.Нацагдорж -96055032 /Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн/ Э.Сансар -99909223 /Баянгол дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга/</p>	Сонгинохайрхан Баянгол
3	<p>Ц.Цэрэнпунцаг -99000969 /Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн дарга/ Д.Энхбат -99084353 /Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга/ Н.Баяр -99119218 /Нийслэлийн өмчийн харилцааны газрын Газар чөлөөлөх хэлтсийн дарга/ /Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын хариуцсан хэлтэс/ Б.Халиунаа -88117306 /Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга/ В.Бэгз -99158434 /Хан Уул дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга/</p>	Баянзүрх Хан Уул

Дөрөв. Шалгах чиглэл

4.1. Холбогдох дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Түргэн үйлчилгээний цэгүүд гэрээ байгуулсан эсэх, дүүргээс зөвшөөрөгдсөн байршилд байрлаж буй эсэх

4.2. Батлагдсан загвартай эсэх /ариун цэврийн өрөө/

4.3. Гадна талбайд зориулалтын хогийн сав байршуулсан эсэх

4.4. Орчин тойрны 50 м хүртэлх зам талбайн угаалга, цэвэрлэгээг тогтмолжуулсан эсэх, хог хаягдлын гэрээтэй эсэх

4.5. Худалдаалж буй бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажилт, хадгалалтын нөхцөл, сав баглаа боодол, хаяг шошгын стандартын шаардлага хангасан байдал

4.6. Зориулалтын хөргүүртэй эсэх

4.7. Хуулиар хориглосон бараа, бүтээгдэхүүн хадгалж, худалдаалж буй эсэх

4.8. Стандартын шаардлага зөрчсөн, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд ажил үйлчилгээ эрхэлж буй эсэх

4.9. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан эсэх

Худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн гаргасан зөрчлийг газар дээр нь арилгуулж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй Түргэн үйлчилгээний цэгүүдийн эзэн холбогдогчийг тогтоон нүүлгэн шилжүүлэх, албадан буулгах асуудлыг зохион байгуулна.

Тав. Шалгалтын дүнг нэгтгэх

5.1. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын авто бааз шалгалтанд шаардлагатай унаа, тээврийн хэрэгслээр бүрэн хангаж ажиллана.

5.2 Шалгалтын дүнг нэгтгэн 2016 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.